

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2026/149/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatar@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Цахим актив аудит ХХК -ын Аудитор: Д.Балжинням Утас:70432545 Цахим хаяг: <a href="mailto:Damiranbaljinnyam573@gmail.com">Damiranbaljinnyam573@gmail.com</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

---

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	12
3.1. Төлбөрийн акт.....	13
3.2 Албан шаардлага .....	13
3.3 Зөвлөмж .....	14
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	16
5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: (976)-7043-3061  
Email: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 193

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХОВД СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ  
ЭМЧ Д.АХГҮЛ ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтууд, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтад заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаартай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй 14.5 сая;
- Түлш шатах тослох материалын жолоочийн замын хуудасны зарцуулалтын тооцоо бодоогүй, анхан шатны баримтгүй, зарцуулалт нотлогдохгүй 1.5 сая;
- Бараа материалын тооллого хийж тооцоо бодоогүй, 28.1 сая төгрөгийн эм боох материалыг бараа материалын тайланд орлого бүртгээгүй, шууд зардалд хүлээн зөвшөөрсөн, эм боох материалыг санхүүгийн программд бөөн дүнгээр орлого бүртгэснээс зардал гаргахад эмийн нэр төрөл, тоо ширхгээр үлдэгдэл зөрсөнтэй холбоотой 10.6 сая;
- Тайлант онд авлага, өглөгийн тооцоо хянаагүйгээс өр үүсгэсэн 41.1 сая;

Ховд сумын Эрүүл мэндийн төвий 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Зардлын эдийн засгийн ангилал зөрчин гүйлгэн зарцуулалт хийсэн 3.2 сая;
- Албан хаагчдын урамшуулалт цалинг давхардуулан олгосон 2.1 сая төгрөгийн зөрчил тус тус илэрсэн.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 3393 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний 47.0 сая төгрөгийн санхүүжилтийн авлага бүртгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд урсгал зардлаас 4.7 сая төгрөгийн, харьяа дээд шатны байгууллагын хөрөнгө оруулалт болон хандив тусламжаар 28.2 сая төгрөг, нийт 32.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 115.3 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 5 зорилго 10 хөтөлбөр, 33 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлээр 95 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд сумын Засаг даргаас 94.8 хувиар дүгнэж, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээг аймгийн Эрүүл мэндийн даатгалын газраас 91.4 хувиар тус тус дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>229,578,130.03</u></b>	<b><u>131,522,705.76</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	1,499,229.84	36,615,052.85
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	1,499,229.84	36,615,052.85
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	1,499,229.84	36,615,052.85
31211	Төрийн сангийн харилцах	1,499,229.84	36,615,052.85
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	167,188,446.29	47,397,205.98
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	128,230.65	128,230.65
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	166,761,867.64	46,970,627.33
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	298,348.00	298,348.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	298,348.00	298,348.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	60,890,453.90	47,510,446.93
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	19,547,502.00	14,498,973.03
35130	Эм боох материал	19,547,502.00	14,498,973.03
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	41,342,951.90	33,011,473.90
35410	Бичиг хэргийн материал	1,718,400.00	2,247,900.00
35420	Аж ахуйн материал	14,027,300.00	14,996,300.00
35460	Хүнсний материал	638,797.90	825,219.90
35470	Бусад хангамжийн материал	24,958,454.00	14,942,054.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>543,099,737.92</u></b>	<b><u>475,365,118.27</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	543,099,737.92	475,365,118.27
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	530,840,252.62	463,162,758.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	298,000,440.62	298,000,440.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	(59,527,425.24)	(70,837,790.88)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	203,672,220.00	203,672,220.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(54,453,137.77)	(103,156,137.37)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	264,460,290.62	283,948,690.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	(125,186,371.95)	(161,252,826.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,131,040.00	32,297,840.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,256,803.66)	(19,509,678.92)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	12,259,485.30	12,202,360.26
39301	Програм хангамж	982,000.00	982,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(821,114.70)	(878,239.74)
39303	Бусад биет бус хөрөнгө	12,098,600.00	12,098,600.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>772,677,867.95</u></b>	<b><u>606,887,824.03</u></b>

Ховд сумын Эрүүл мэндийн төвий 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>53,628,483.52</b>	<b>41,925,705.94</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	53,628,483.52	41,925,705.94
<b>413</b>	<b>Өглөг</b>	53,628,483.52	41,925,705.94
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	35,942,641.14	26,400,518.56
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	17,685,842.38	15,525,187.38
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>719,049,384.43</b>	<b>564,962,118.09</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	719,049,384.43	564,962,118.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	160,773,037.00	160,773,037.00
51101	Өмч: - төрийн	160,773,037.00	160,773,037.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	435,957,465.99	281,870,199.65
51210	Өмнөх үеийн үр дүн	435,957,465.99	435,957,465.99
51220	Тайлант үеийн үр дүн	-	(154,087,266.34)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	122,318,881.44	122,318,881.44
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>772,677,867.95</b>	<b>606,887,824.03</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,160,729,008.10</b>	<b>1,140,350,207.73</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>238,957,916.35</b>	<b>95,558,242.03</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	238,957,916.35	95,558,242.03
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	238,957,916.35	95,558,242.03
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	837,800.00	63,370,868.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	238,120,116.35	32,187,374.03
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>921,771,091.75</b>	<b>1,044,791,965.70</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	21,011,900.00	42,207,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,011,900.00	42,207,400.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	753,741,237.11	1,002,584,565.70
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	753,741,237.11	1,002,584,565.70
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>902,181,814.01</b>	<b>1,294,437,474.07</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>902,181,814.01</b>	<b>1,294,437,474.07</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	902,181,814.01	1,234,869,998.74
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	618,645,518.52	878,334,228.47
210101	Үндсэн цалин	356,354,312.69	510,924,660.51
210102	Нэмэгдэл	181,313,165.83	253,703,353.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,777,000.00	59,534,646.96
210104	Урамшуулал	50,201,040.00	54,171,568.00

Ховд сумын Эрүүл мэндийн төвий 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	67,823,439.03	101,694,961.95
210201	Тэтгэврийн даатгал	46,119,938.53	69,152,574.10
210202	Тэтгэмжийн даатгал	5,425,875.12	8,135,596.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,712,937.57	4,067,798.50
210204	Ажилгүйдлийн даатгал	2,712,937.57	4,067,798.50
210205	Эрүүл мэндийн даатгал	10,851,750.24	16,271,193.90
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,888,857.81	40,714,057.67
210301	Гэрэл, цахилгаан	2,030,146.16	2,961,424.67
210302	Түлш, халаалт	32,858,711.65	37,752,633.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	31,117,355.02	42,080,570.00
210401	Бичиг хэрэг	3,574,020.00	2,894,400.00
210402	Тээвэр, шатахуун	20,878,150.00	25,388,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,835,000.00	3,770,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,830,185.02	9,577,970.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	450,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	68,844,988.99	36,746,826.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,789,486.99	25,859,148.00
210502	Хоол, хүнс	9,055,502.00	10,887,678.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,415,453.84	25,794,025.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	20,081,225.00
210604	Урсгал засвар	2,965,453.84	5,712,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,440,000.00	2,150,000.00
210702	Дотоод албан томилолт	1,440,000.00	2,150,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	964,000.00	4,230,287.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	414,000.00	2,042,087.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	1,008,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	786,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	220,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	174,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	71,042,200.80	103,125,042.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,078,600.00	2,451,223.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,963,600.80	100,673,819.65
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	59,567,475.33
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	59,022,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	59,022,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	545,475.33

Ховд сумын Эрүүл мэндийн төвий 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	545,475.33
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>258,547,194.09</u></b>	<b><u>(154,087,266.34)</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>258,547,194.09</u></b>	<b><u>(154,087,266.34)</u></b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>774,753,137.11</u></b>	<b><u>1,227,954,074.01</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>63,370,868.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	63,370,868.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	63,370,868.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	63,370,868.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>774,753,137.11</b>	<b>1,164,583,206.01</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	21,011,900.00	42,207,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,011,900.00	42,207,400.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	753,741,237.11	1,122,375,806.01
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	753,741,237.11	1,122,375,806.01
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>805,416,160.08</u></b>	<b><u>1,188,158,251.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>805,416,160.08</b>	<b>1,188,158,251.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>803,855,706.24</b>	<b>1,128,590,775.67</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	577,505,438.24	821,263,300.00
210101	Үндсэн цалин	306,002,525.71	366,162,089.20
210102	Нэмэгдэл	181,982,316.29	285,741,210.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,790,261.22	63,360,000.00
210104	Урамшуулал	58,730,335.02	106,000,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	73,239,600.00	102,364,800.00
210201	Тэтгэврийн даатгал	52,042,800.00	68,857,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,299,600.00	8,376,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,649,500.00	4,188,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,649,500.00	4,188,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,598,200.00	16,753,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,984,646.16	38,387,624.67
210301	Гэрэл, цахилгаан	2,030,146.16	3,043,124.67
210302	Түлш, халаалт	34,954,500.00	34,954,500.00
210303	Цэвэр, бохир ус	-	390,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	30,258,620.00	40,518,900.00

Ховд сумын Эрүүл мэндийн төвий 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	2,965,620.00	3,231,250.00
210402	Тээвэр, шатахуун	19,081,700.00	24,099,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,835,000.00	3,770,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,066,200.00	5,600,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,310,100.00	3,818,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>43,246,548.00</b>	<b>74,448,246.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,489,248.00	59,755,046.00
210502	Хоол, хүнс	8,507,300.00	13,005,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,250,000.00	1,687,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>33,602,853.84</b>	<b>35,575,525.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,065,600.00	29,751,225.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,321,800.00	550,000.00
210604	Урсгал засвар	3,215,453.84	5,274,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,440,000.00</b>	<b>1,800,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,440,000.00	1,800,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>964,000.00</b>	<b>3,849,387.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	414,000.00	2,600,087.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	25,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	220,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	174,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,614,000.00</b>	<b>10,382,993.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,614,000.00	10,382,993.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,560,453.84</b>	<b>59,567,475.33</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>59,022,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	59,022,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,560,453.84</b>	<b>545,475.33</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,560,453.84	545,475.33
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>(30,663,022.97)</u></b>	<b><u>39,795,823.01</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>4,680,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>4,680,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>4,680,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж	-	4,680,000.00

Ховд сумын Эрүүл мэндийн төвий 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(4,680,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(30,663,022.97)	35,115,823.01
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,499,229.84
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,499,229.84	36,615,052.85

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	160,773,037.00	122,318,881.44	177,410,271.90	460,502,190.34
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	160,773,037.00	122,318,881.44	177,410,271.90	460,502,190.34
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	258,547,194.09	258,547,194.09
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	160,773,037.00	122,318,881.44	435,957,465.99	719,049,384.43
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	160,773,037.00	122,318,881.44	435,957,465.99	719,049,384.43
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	160,773,037.00	122,318,881.44	435,957,465.99	719,049,384.43
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(154,087,266.34)	(154,087,266.34)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	160,773,037.00	122,318,881.44	281,870,199.65	564,962,118.09

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,234,668,624.67	1,192,292,775.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,234,668,624.67	1,187,612,775.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,166,292,624.67	1,128,590,775.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	821,263,300.00	821,263,300.00
210101	Үндсэн цалин	371,239,200.00	366,162,089.20
210102	Нэмэгдэл	280,664,100.00	285,741,210.80

Ховд сумын Эрүүл мэндийн төвий 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	63,360,000.00	63,360,000.00
210104	Урамшуулал	106,000,000.00	106,000,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>102,364,800.00</b>	<b>102,364,800.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	68,857,600.00	68,857,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,376,800.00	8,376,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,188,400.00	4,188,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,188,400.00	4,188,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,753,600.00	16,753,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,387,624.67</b>	<b>38,387,624.67</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,043,124.67	3,043,124.67
210302	Түлш, халаалт	34,954,500.00	34,954,500.00
210303	Цэвэр, бохир ус	390,000.00	390,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>42,834,600.00</b>	<b>40,518,900.00</b>
210401	Бичиг хэрэг	3,231,300.00	3,231,250.00
210402	Тээвэр, шатахуун	24,547,700.00	24,099,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,938,900.00	3,770,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,366,400.00	5,600,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,750,300.00	3,818,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>75,102,900.00</b>	<b>74,448,246.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,097,900.00	59,755,046.00
210502	Хоол, хүнс	12,755,000.00	13,005,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,250,000.00	1,687,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>68,236,200.00</b>	<b>35,575,525.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	61,761,900.00	29,751,225.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,200,000.00	550,000.00
210604	Урсгал засвар	5,274,300.00	5,274,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,800,000.00</b>	<b>1,800,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	1,800,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,180,100.00</b>	<b>3,849,387.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,566,500.00	2,600,087.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	25,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	258,600.00	220,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	174,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,123,100.00</b>	<b>10,382,993.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,123,100.00	10,382,993.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>68,376,000.00</b>	<b>59,022,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>68,376,000.00</b>	<b>59,022,000.00</b>

Ховд сумын Эрүүл мэндийн төвий 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	68,376,000.00	59,022,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>4,680,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	4,680,000.00
222001	Тоног төхөөрөмж		4,680,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,234,668,624.67	1,227,408,598.68
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	41,661,924.67	41,661,924.67
132001	Орон нутгийн төсвөөс	41,661,924.67	41,661,924.67
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,129,635,832.00	1,122,375,806.01
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,129,635,832.00	1,122,375,806.01
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	63,370,868.00	63,370,868.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	63,370,868.00	63,370,868.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>1,499,229.84</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>36,615,052.85</b>

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 102,108.7 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> зөрчил илэрч, санхүүгийн тайланд 803.3 мянган төгрөгийн алдааг залруулга хийлгэлээ. Үүнд:

- Тайлант онд үүссэн НДШ-н өглөгийг тайланд дутуу тусгасан 803.3 мянган төгрөг

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй 101,305.4 мянган төгрөгийн 6 зөрчил<sup>2</sup> илэрсэнд 1,542.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг таслан зогсоох 53,287.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 46,476.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 13,424.7 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.1. Төлбөрийн акт

**Илрүүлэлт:** Тайлант онд зарцуулсан шатахууны тооцоог анхан шатны баримттай тулган шалгахад 514 литр 1,542.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалт нотлогдохгүй, анхан шатны баримтгүй зарлагадсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

### 3.2 Албан шаардлага

**Илрүүлэлт:** Тайлант онд Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй, уг эм, эмнэлгийн хэрэгслийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй, орлогын баримтгүйгээр төлбөрийг төлж, шууд зардалд бүртгэсэнтэй холбоотой 14,484.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.2-т "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны 01/103 албан тоотын заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### Бараа материалын эм, эмнэлгийн хэрэгслийн данстай холбоотой

**Илрүүлэлт:** Тайлант оны эм эмнэлгийн хэрэгслийн орлого болон зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгахад бараа материалын тайлангаарх эм боох материалын үлдэгдэл болох 14,499.0 мянган төгрөгөөс 108 нэр төрлийн 10,604.9 мянган төгрөгийн бодитоор оршин байхгүй өөр нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл байгаа, бөөн дүнгээр орлого авч, зарцуулалт баримтаар нотлогдохгүй 19,456.7 мянган төгрөг, тайлант онд худалдаж авсан 8,741.5 мянган төгрөгийн эм боох материалыг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй эм зүйч эм боох материалын орлогыг бөөн дүнгээр бүртгэж, зарлагдаж байгаа бүртгэлийн алдаатай холбоотой 38,803.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь хариуцсан албан тушаалтнууд албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил,

гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй ...", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Сангийн сайдын 2025 А/03 тушаал Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журмын хавсралтын 8 зүйлийн 8.2.-д "Бараа материал нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, хангамжийн материал, нөөцийн бараа, бусад бараа материал бүрдэнэ.", 8.3.-д Бараа материалыг УСНББОУС 12 "Бараа материал"-ын дагуу бүртгэнэ." гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах, бараа материалын тооллогыг цаг хугацаанд нь үнэн зөв иж бүрэн хийж тооцоо бодох, эм боох материалыг нэр төрөл, тоо ширхгээр бүртгэлд тусгах, бусдад өгөх төлбөр тооцоог өглөгийн дансаар дамжуулан давхар бичилтийн аргаар бүртгэх талаарх албан шаардлага хүргүүлэв.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **3.3.1 Өглөгийн данстай холбоотой**

**Илрүүлэлт.** Тайлант онд дансны авлага, өглөг төлбөр тооцоог хянаагүйгээс ажилчидтай холбоотой 25.6 сая, түлш халаалтын 4.6 сая, тээвэр шатахууны 2.9 сая, албан томилолтын 0.3 сая, эм, боох материалын 7.6 сая, нийт 41.1 сая төгрөгийн өглөг үүсгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Дансны өглөг, авлагын тооцоог хянан баталгаажуулж барагдуулах ажил зохион байгуулах

#### **3.3.2 Эдийн засгийн ангилалт, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тайлант онд орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 3,216.0 мянган төгрөгийг зориулалт бусаар сэлбэг хэрэгслийн зардалд зарцуулж, эдийн засгийн ангилал зөрчин гүйлгэн зарцуулалт хийсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", хоёрдугаар хавсралт "Зардлын эдийн засгийн ангилалын тайлбар"-ын Хэрэглүүрийн гуравт: "Төсөв боловсруулж батлуулах, гүйцэтгэлийн тайлан гаргах, зардлын хяналт, аудит хийхэд ашиглана", Төсвийн захирагчийн үүрэгт: "Зардлын ангилалын тодорхойлолтод заасны дагуу нийцүүлж зөв бүртгэх, мэдээлэх, тайлагнах үүргийг төсвийн бүх шатны захирагчид хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Зардлын зүйл ангийг эдийн засгийн ангиллын дагуу зөв бүртгэж, зарцуулалтыг үнэн зөв гаргах

### **5.3.3 Цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой асуудлаар**

**Илрүүлэлт:** Тайлант онд олгосон цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг анхан шатны баримттай тулган шалгахад урамшуулалт цалинг 5,6 саруудад улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" 15.1.3-д "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цалин хөлсний нэмэгдлийг засгийн газрын тогтоолын дагуу олгох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НДШ-н өглөгийг дутуу тусган бүртгэсэн	1	803.3	1	803.3			1	803.3
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>803.3</b>	<b>1</b>	<b>803.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>803.3</b>

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
Тайлант онд зарцуулсан шалгахад 514 литр шатахууны зарцуулалт нотлогдохгүй, анхан шатны баримтгүй зарлагадсан	1	1,542.0	1	1,542.0							
Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй,	1	14,484.0			1	14,484.0					
Эм боох материалын нэр төрөл үнийн дүн зөрүүтэй, бөөн дүнгээр орлого авч шууд зардалд бүртгэж зарлагадсан, худалдаж авсан эм боох материалыг дутуу бүртгэсэн	1	38,803.1							1	38,803.1	
Тайлант онд дансны авлага, өглөг төлбөр тооцоог хянаагүйгээс өр төлбөр үүсгэсэн	1	41,122.3					1	41,122.3			
Тайлант онд орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас эдийн засгийн ангилал зөрчин гүйлгэн зарцуулалт хийсэн	1	3,216.0					1	3,216.0			
Урамшуулалт цалинг 5. 6 саруудад улирлын үр дүнгийн урамшуулалттай давхардуулаан олгосон	1	2,138.0					1	2,138.0			
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>101,305.4</b>	<b>1</b>	<b>1,542.0</b>	<b>1</b>	<b>14,484.0</b>	<b>3</b>	<b>46,476.3</b>	<b>1</b>	<b>38,803.1</b>	

**5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА  
САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		